

Улирлын урьдчилсан төлөв


НЭГ. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Хиймэл оюун ухаан, Тоон загварчлал, Судалгааны Хэлтэс (ХОУТЗСХ)–ээс 2026 оны 5 дугаар сараас 7 дугаар саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна. Урьдчилсан төлөвийг weather.gov.mn цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу. Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ХОУТЗСХ-ээс тодруулах боломжтой.


ХОЁР. УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

2.1 5–7 дугаар саруудын уур амьсгал

Агаарын температур тавдугаар сард Баян-Өлгийн нутаг, Увс, Архангайн баруун, Ховдын төв, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Хөвсгөлийн ихэнх, Өвөрхангай, Хэнтийн баруун хойд, Төвийн зүүн хойд хэсгээр 0...6°C, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар 12...18°C, бусад нутгаар 6...12°C дулаан байдаг (**Зураг 1а**). Хур тунадасны хувьд Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 20 – 30 мм, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 0 – 10 мм, бусад нутгаар 10–20 мм ордог (**Зураг 2а**).




Зураг 1а. 5 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)




Зураг 2а. 5 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

Зургаадугаар сард Баян–Өлгий, Завхан, Хөвсгөлийн ихэнх нутаг, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 6–12°C, Ховд, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Дорноговь, Өмнөговийн нутгаар 20–24°C, бусад нутгаар 13–19°C дулаан байдаг байна (**Зураг 3а**). Хур тунадас Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 60–70 мм, Их Нуруудын Хотгор, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 10–20 мм, бусад нутгаар 20–60 мм хүртэл хур тунадас ордог байна (**Зураг 4а**).




Зураг 3а. 6 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)




Зураг 4а. 6 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

Долоодугаар сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар $+8...+14^{\circ}\text{C}$, Алтайн өвөр говь болон говь талын нутгаар $+20...+26^{\circ}\text{C}$, бусад нутгаар $+14...+20^{\circ}\text{C}$ (**Зураг 5а**). Хур тунадас Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 70–100 мм, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 0–30 мм, бусад нутгаар 30–70 мм бороо ордог байна (**Зураг 6а**).



Зураг 5а. 7 дугаар сарын агаарын температурын ОЖД (1991-2020)




Зураг 6а. 7 дугаар сарын хур тунадасны ОЖД (1991-2020)

ГУРАВ. 2026 ОНЫ 5–7 ДУГААР САРУУДЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2026 оны 5 дугаар сараас 7 дугаар саруудын цаг агаарын урьдчилсан төлөв


Тавдугаар сард. Агаарын дундаж температур Сэлэнгэ, Төвийн зүүн, Хэнтий, Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД-ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 16**).



Зураг 16. 2026 оны 5 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Н-агаарын температур ОЖД-ын орчим, Д-агаарын температур ОЖД-аас дулаан]


Нийлбэр хур тунадас Төв, Сэлэнгийн зүүн, Хэнтий, Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД-аас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 26**).



Зураг 26. 2026 оны 5 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[Н–хур тунадас ОЖД–ийн орчим, Б–хур тунадас ОЖД–аас бага]


Зургаадугаар сард. Агаарын дундаж температур Увс, Завханы нутаг, Баян–Өлгийн зүүн хойд, Ховд, Говь–Алтайн хойд хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 36**).



Зураг 36. 2026 оны 6 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Н-агаарын температур ОЖД-ын орчим, Д-агаарын температур ОЖД-аас дулаан]


Нийлбэр хур тунадас Увс, Завханы нутаг, Ховдын зүүн хойд, Говь-Алтай, Баянхонгорын хойд, Хөвсгөл, Архангайн баруун хэсгээр ОЖД-аас ахиу, Хэнтий, Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД-аас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 46**).



Зураг 46. 2026 оны 6 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)

[И-хур тунадас ОЖД-аас ахиу, Н-хур тунадас ОЖД-ийн орчим, Б-хур тунадас ОЖД-аас бага]


Долоодугаар сард. Агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД-аас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 56**).



Зураг 5б. 2026 оны 7 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)

[Д–агаарын температур ОЖД–аас дулаан]

7 дугаар сарын нийлбэр хур тунадас нийт нутгаар ОЖД–аас бага байх төлөвтэй байна (Зураг 6б).



Зураг 6б. 2026 оны 7 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[Б–хур тунадас ОЖД–аас бага]

3.2 Зөвлөмж

Ирэх саруудад ихэнх нутгаар олон жилийн дунджаас дулаан, хур тунадас нутгийн зүүн хэсгээр дунджаас бага орох төлөвтэй байна. Түүнчлэн хүчтэй салхи, шороон шуурганы давтагдал их байх ба хуурайшилт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Иймээс малчид, тариаланчид, ард иргэд хүчтэй салхи шуурганы аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авч, болзошгүй тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлж, хээр талд гал алдахгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөж байна.